



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/252-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар

Утас: 99499667 Цахим хаяг: [infoauditselenge@gmail.com](mailto:infoauditselenge@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>ТӨБЗГ</b>	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>БЕГ</b>	Боловсролын ерөнхий газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ХНХС</b>	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БҮХТ</b>	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв
<b>ОУБ</b>	Олон улсын байгууллага
<b>ХНХЯ</b>	Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам



СЭЛЭНГЭ АЙМГИЙН МЭРГЭЖИЛ СУРГАЛТ  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ  
Д.ЗАГДГОЧОО ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-20 № СА-2023/152-НАЕМУС

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 1,408,465.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 83.8 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 16.2 хувиар хэмнэсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар өгөгдсөн чиглэлийн дагуу цалин, ажил олгогчоос төлөх НДШ, хоолны зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хичээл дадлагын зардлаас нийт 227,733.4 мянган төгрөгийг хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

0180200593

## **Аудитын гол асуудал**

2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 71.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 12.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 6.8 хувийг тэтгэмж урамшууллын /тайлант онд 2 ажилтан өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 6 ажилтан хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг авсан/ зардал тус тус эзэлж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>268,523,981.04</b>	<b>290,176,309.41</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>46,441.00</b>	<b>431,919,930.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	46,441.00	MPC400659055436
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	-	<b>91,930.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	91,930.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>268,477,540.04</b>	<b>290,084,379.41</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>128,962,826.97</b>	<b>132,668,702.13</b>
35110	Тусгай зориулалттай материал	128,503,126.97	131,626,982.13
35130	Эм боох материал	459,700.00	1,041,720.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>139,514,713.07</b>	<b>157,415,677.28</b>
35410	Бичиг хэргийн материал	1,530,280.00	289,050.00
35420	Аж ахуйн материал	12,423,587.04	10,524,369.50
35430	Сэлбэг хэрэгсэл	60,000.00	2,089,600.00
35440	Түлш, шатах тослох материал	20,489,692.75	17,432,903.50
35450	Барилгын засварын материал	6,497,521.78	18,313,849.78
35460	Хүнсний материал	1,174,200.00	128,158.00
35470	Бусад хангамжийн материал	97,339,431.50	108,637,746.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,765,916,659.29</b>	<b>3,525,566,454.06</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,765,916,659.29</b>	<b>3,525,566,454.06</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,021,347,784.15</b>	<b>2,778,390,495.52</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,473,094,455.84	2,473,094,455.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(281,879,701.80)	(379,018,500.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,229,021.25	127,953,908.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(96,535,438.58)	(85,962,525.47)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,031,568,841.42	1,049,176,229.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(460,147,756.62)	(607,390,557.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	208,339,542.33	198,930,892.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(148,602,703.13)	(144,284,993.53)
39209	Зам, гүүрийн байгууламж	40,696,967.89	40,696,967.89
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,339,412.16)	(9,785,882.88)
39217	Ном	113,923,967.71	114,980,501.04
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>744,568,875.14</b>	<b>747,175,958.54</b>
39301	Программ хангамж	15,408,000.00	3,908,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(15,211,124.86)	(1,104,041.46)
39303	Бусад биет бус хөрөнгө	744,372,000.00	744,372,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,034,440,640.33</b>	<b>3,815,742,763.47</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>106,500.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>106,500.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	-	<b>106,500.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>106,500.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	106,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,034,440,640.33</b>	<b>3,815,636,263.47</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,034,440,640.33</b>	<b>3,815,636,263.47</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,637,215,244.56	2,637,215,244.56
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	-	2,637,215,244.56
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(796,967,122.86)</b>	<b>(1,056,760,119.72)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(503,060,329.41)	(796,967,122.86)
51220	Тайлант үеийн үр дүн	(293,906,793.45)	(259,792,996.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,194,192,518.63	2,235,181,138.63
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,034,440,640.33</b>	<b>3,815,742,763.47</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,143,571,449.90</b>	<b>1,406,634,307.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,418,149.90</b>	<b>37,360,660.08</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>15,418,149.90</b>	<b>37,360,660.08</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,372,300.00</b>	<b>73,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,372,300.00	73,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,208,773.36	30,045,691.33
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,837,076.54	7,241,968.75
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,128,153,300.00</b>	<b>1,369,273,647.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,128,153,300.00</b>	<b>1,154,012,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,128,153,300.00	1,154,012,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>3,705,650.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,705,650.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>211,555,497.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	211,555,497.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,437,478,243.35</b>	<b>1,666,427,303.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,437,478,243.35</b>	<b>1,666,427,303.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,265,721,930.46</b>	<b>1,400,836,671.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>681,502,290.00</b>	<b>741,909,137.33</b>
210101	Үндсэн цалин	365,103,653.00	523,727,168.33
210102	Нэмэгдэл	195,758,085.00	135,449,626.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,742,093.00	39,978,200.00
210104	Урамшуулал	39,898,459.00	42,754,143.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>89,802,780.05</b>	<b>98,598,858.07</b>
210201	Тэтгэврийн даатгал	63,199,236.40	69,567,358.69
210202	Тэтгэмжийн даатгал	7,009,053.29	7,595,897.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,432,522.71	5,969,197.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,287,451.55	1,401,416.82
210205	Эрүүл мэндийн даатгал	12,874,516.10	14,064,987.26
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>109,255,237.06</b>	<b>146,531,595.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,516,500.06	23,638,860.00
210302	Түлш, халаалт	80,885,805.00	98,678,897.00
210303	Цэвэр, бохир ус	10,852,932.00	23,068,878.00
210304	Байрны түрээс	-	1,144,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,508,517.62</b>	<b>23,094,144.79</b>
210401	Бичиг хэрэг	3,556,230.00	5,339,837.75
210402	Тээвэр, шатахуун	4,198,900.00	4,684,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,452,340.00	4,530,890.00
210404	Ном, хэвлэл	-	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,695,000.00	2,422,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,850,047.62	6,066,447.04
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	756,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	30,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,274,689.52</b>	<b>15,821,329.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	486,689.52	125,190.00
210502	Хоол, хүнс	15,788,000.00	15,448,639.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	247,500.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,056,480.00</b>	<b>17,019,212.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	595,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	369,600.00	-
210604	Урсгал засвар	3,686,880.00	16,424,212.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>821,600.00</b>	<b>2,087,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	821,600.00	2,087,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,543,892.00</b>	<b>11,416,041.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	634,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,350,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,059,996.00	8,047,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,216.00	422,716.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	230,000.00	230,000.00
210807	Газрын төлбөр	545,680.00	582,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>328,956,444.21</b>	<b>344,359,154.65</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,860,611.64	27,536,438.09
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	312,095,832.57	316,822,716.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>171,756,312.89</b>	<b>265,590,632.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>117,371,600.00</b>	<b>80,681,200.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,184,700.00	41,897,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,686,900.00	37,833,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	950,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>54,384,712.89</b>	<b>184,194,017.10</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,384,712.89	184,194,017.10
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>715,415.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	715,415.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(293,906,793.45)</b>	<b>(259,792,996.86)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(293,906,793.45)</b>	<b>(259,792,996.86)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,129,525,600.00</b>	<b>1,369,346,647.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,372,300.00</b>	<b>73,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,372,300.00</b>	<b>73,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,372,300.00</b>	<b>73,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,372,300.00	73,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,128,153,300.00</b>	<b>1,369,273,647.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,128,153,300.00</b>	<b>1,154,012,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,128,153,300.00	1,154,012,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>3,705,650.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,705,650.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>211,555,497.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	211,555,497.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,125,960,600.00</b>	<b>1,363,908,447.00</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,125,960,600.00</b>	<b>1,363,908,447.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>954,204,287.11</b>	<b>1,098,317,814.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>681,548,731.00</b>	<b>745,822,688.28</b>
210101	Үндсэн цалин	403,610,219.00	549,337,442.28
210102	Нэмэгдэл	166,329,096.00	142,387,349.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,848,300.00	30,658,382.00
210104	Урамшуулал	37,761,116.00	23,439,515.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>89,802,780.05</b>	<b>94,693,843.62</b>
210201	Тэтгэврийн даатгал	63,199,236.40	65,875,720.67
210202	Тэтгэмжийн даатгал	7,009,053.29	7,600,097.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,432,522.71	5,949,038.03
210204	Ажилгүйдлийн даатгал	1,287,451.55	1,382,993.80
210205	Эрүүл мэндийн даатгал	12,874,516.10	13,885,993.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>119,245,237.06</b>	<b>144,667,095.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,516,500.06	23,638,860.00
210302	Түлш, халаалт	90,875,805.00	96,814,397.00
210303	Цэвэр, бохир ус	10,852,932.00	23,068,878.00
210304	Байрны түрээс	-	1,144,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,415,485.00</b>	<b>21,083,603.50</b>
210401	Бичиг хэрэг	3,563,950.00	2,974,699.00
210402	Тээвэр, шатахуун	2,443,900.00	4,684,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,452,340.00	4,530,890.00
210404	Ном, хэвлэл	-	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,340,000.00	2,534,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,615,295.00	6,339,244.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>14,531,000.00</b>	<b>20,514,807.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	189,400.00	707,210.00
210502	Хоол, хүнс	12,718,600.00	14,402,597.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,623,000.00	5,405,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,917,230.00</b>	<b>31,360,280.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	260,000.00	43,780.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	1,558,500.00
210604	Урсгал засвар	3,857,230.00	29,758,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>821,600.00</b>	<b>2,087,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	821,600.00	2,087,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,543,892.00</b>	<b>11,557,041.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	881,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,350,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,059,996.00	8,047,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,216.00	358,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	230,000.00	230,000.00
210807	Газрын төлбөр	545,680.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,378,332.00</b>	<b>26,531,256.50</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,378,332.00	26,531,256.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>171,756,312.89</b>	<b>265,590,632.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>117,371,600.00</b>	<b>80,681,200.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,184,700.00	41,897,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,686,900.00	37,833,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	950,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>54,384,712.89</b>	<b>184,194,017.10</b>

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,384,712.89	184,194,017.10
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	<b>715,415.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		715,415.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>3,565,000.00</b>	<b>5,438,200.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,565,000.00</b>	<b>5,438,200.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,565,000.00</b>	<b>5,438,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,565,000.00</b>	<b>5,438,200.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,565,000.00	5,438,200.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(3,565,000.00)</b>	<b>(5,438,200.00)</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,637,215,244.56	2,194,192,518.63	(796,967,122.86)	4,034,440,640.33
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,637,215,244.56</b>	<b>2,194,192,518.63</b>	<b>(796,967,122.86)</b>	<b>4,034,440,640.33</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	40,988,620.00	-	40,988,620.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(259,792,996.86)	(259,792,996.86)
<b>20</b>	<b>2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>2,637,215,244.56</b>	<b>2,235,181,138.63</b>	<b>(1,056,760,119.72)</b>	<b>3,815,636,263.47</b>





## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,705,650.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,705,650.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,705,650.00</b>
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,144,960.00</b>
210304	Байрны түрээс	1,144,960.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,577,190.00</b>
210401	Бичиг хэрэг	83,000.00
210402	Тээвэр, шатахуун	240,070.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,254,120.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>102,000.00</b>
210604	Урсгал засвар	102,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>881,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	881,500.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,706,650.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,705,650.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,705,650.00



## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь “Багш, ажилтан, суралцагчдын мэргэжил, ур чадварыг байнга дээшлүүлж тэдний ажиллах ая тухтай таатай орчинг бүрдүүлж ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах,
- Хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах,
- Үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,

- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Байгууллагын дотоод хяналтын албанаас ажлын төлөвлөгөө гарган хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, дотуур байрны үйл ажиллагаа, цалин хөлс, урамшууллын сангийн зарцуулалт, өр авлага түүний барагдуулалт, боловсролын бичиг баримтын бүрдүүлэлт, тэтгэлгийн ирцэд хяналт тавих зэрэг ажлуудыг төлөвлөн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас байгууллагын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох эрхийн актуудыг 94,0-96.0 хувьтай хэрэгжүүлэн төсвийн хөрөнгийг зориулалтаар нь үр дүнтэй зарцуулж тайлагнасан байна гэж дүгнэжээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх

итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, 4 нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 218,627.9 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	46.4	91.9	45.5
Бараа материал	268,477.5	290,084.4	21,606.8
Үндсэн хөрөнгө	3,765,916.7	3,525,566.5	(240,350.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,034,440.6</b>	<b>3,815,742.8</b>	<b>(218,697.9)</b>
Өр төлбөр	-	106.5	106.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,034,440.6	3,815,636.3	(218,804.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,034,440.6</b>	<b>3,815,742.8</b>	<b>(218,697.9)</b>

Авлага дансны үлдэгдэл 91.3 мянган төгрөг болж 45.5 мянган төгрөгөөр өссөн нь хүүхдээ асрах чөлөө авсан ажилтнаас илүү олгосон цалингийн суутгал хийгдээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 290,084.4 мянган төгрөг болж 21,606.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 161,718.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, Дэлхийн зөн ОУБ-аас 3,752.4 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, “Чинбатын Ундрэм” сангаас Вюрт Монголиа ХХК-аар дамжуулан 3,198.5 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, төгсөгчдөөс 270.0 мянган төгрөгийн индукцэн плитка зэрэг нийт 7,220.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 147,332.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,753,112.9 мянган төгрөг болж 22,519.9 мянган төгрөгөөр буурсан нь дараах ажил гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 5,438.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан,
- БШУЯ-наас 21.7 мянган төгрөгийн ном, Дэлхийн зөн ОУБ-аас 5,964.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, “Чинбатын Ундрэм” сангаас Вюрт Монголиа ХХК-аар дамжуулан 21,301.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ХНХЯамнаас 18.0 мянган төгрөгийн ном, хичээл дадлагаар 2,740.0 мянган төгрөгийн сандал, эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан,
- ТӨБЗГ-ын 2022 оны 17 тогтоолоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 25 нэрийн нийт 98,992.3 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 40,988.6 мянган төгрөгөөр үнэлж орлогод авсан зэрэг.

Өр төлбөр дансны үлдэгдэл 106.5 мянган төгрөг болж өссөн нь нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас 64.5 мянган төгрөгийн агаарын бохирдол, 42.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн өглөг үүссэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,815,742.8 мянган төгрөг болж 218,697.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,130,440.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 261,097.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,391,538.2 мянган төгрөгөөр тоцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 46,172.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5,771.7 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 4,058.7 мянган төгрөгөөр өсгөн, байр ашиглалттай холбоотой зардлыг 28,034.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 4,615.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 1,881.9 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,260.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,645.2 мянган төгрөгөөр, тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 13,152.1 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт төсвийг 1,390,744.2 мянган төгрөгөөр баталсан байна.



2022 оны 3 дугаар сард цалингийн зардлыг 42,186.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5,192.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж, байр ашиглалттай холбоотой зардалд 50,100.0 мянган төгрөгийг, урсгал засварын зардалд 15,000.0 мянган төгрөгийг нэмж төсвийн зохицуулалт хийснээр улсын төсвөөс 1,154,012.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 254,452.5 мянган төгрөг зэрэг нийт 1,408,465.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,154,012.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 254,452.5 мянган төгрөг, нийт 1,408,465.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,180,731.6 мянган төгрөг буюу 83.8 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 135,708.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 15,578.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлаас 42,161.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 3,753.9 мянган төгрөг, нормативт зардал 25,419.5 мянган төгрөг, урсгал засварын зардлаас 3,682.5 мянган төгрөг, томилолтын зардал 977.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 128.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 284.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 38.9 мянган төгрөг, нийт 227,733.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71804 Мэргэжлийн боловсрол	1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	1,034,442.4	874,807.7	159,634.71	84.6
		2	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж,	80,720.1	80,681.2	38.9	99.9
		3	81806- Дотуур байрны үйлчилгээ	38,850.0	14,402.6	24,447.4	37.1
		4	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	192,167.3	149,318.8	42,848.5	77.7
		5	80112- Нийтлэг үйлчилгээ	62,285.2	61,521.3	763.9	98.8
		<b>Нийт</b>		<b>1,408,465.0</b>	<b>1,180,731.6</b>	<b>227,733.4</b>	<b>83.8</b>



#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,437,478.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,374.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Цалин, ажил олгогчоос төлөх НДШ, хоолны зардал, байр ашиглалттай холбоотой зардал, хичээл дадлагын зардлаас нийт 227,733.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.



#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын 2022 оны 11 дүгээр 02-ны өдрийн 22/53 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд олгосон 1,792.2 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах төлбөрийн акт, төлбөрийн цахим баримттай холбоотой 48,437.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган  
төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,792.2	1	1,792.2	100.0
Зөвлөмж	1	48,437.1	1	48,437.1	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>53,389.3</b>	<b>2</b>	<b>53,389.3</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь 2022 онд Сүхбаатар суманд зохиогдсон үзэсгэлэн худалдаанд оролцон бүтээгдэхүүн борлуулсаны 759.8 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэн төсөвт төвлөрүүлсэн боловч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тооцоо тайланг үйлдээгүй, тоо хэмжээ, өртгийн тооцоолол тодорхойлох боломжгүй байна. Иймд дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,448.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 2,469.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 413.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 565.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

## 5.1 Төлбөрийн акт

1. Сахиул Б.Даваасүрэнд өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжтэй давхардуулан Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.5 дахь заалтыг үндэслэн 4 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу 2,093.6 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон тэтгэмжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Сануулах сахилгын шийтгэл ногдуулсан багш С.Ганцоожийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад улирлын ажлын үр дүнгийн урамшуулал 376.3 мянган төгрөг олгосон байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дүгээр зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтын 4.3 дахь "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

## 5.2 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас тайлант онд 106.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Бэлнээр төвлөрүүлсэн Спорт заалны түрээсийн орлого 307.2 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд тушаалгүйгээр шууд захиран зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн

өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Нийгмийн даатгалын шимтгэл, тайлагналтай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Гагнуурчин, дадлагын багш Б.Эрдэнэхангайн 3 дугаар сарын цалингийн 565.2 мянган төгрөгийг нийгмийн даатгалын байгууллагад дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, түүнд ногдох НДШ-ийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнаж, тогтоосон хугацаанд төлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэтгэмж давхардуулан олгосон	1	2,093.6	1	2,093.6								
Сахилгын шийтгэл ногдуулсан багшид үр дүнгийн урамшуулал олгосон.	1	376.3	1	376.3								
Мөнгөн кассын журам зөрчсөн	1	307.2			1	307.2						
Өр төлбөр үүсгэсэн	1	106.5			1	106.5						
Нийгмийн даатгалд цалин дутуу тайлагнасан.	1	565.2					1	565.2				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>3,448.8</b>	<b>2</b>	<b>2,469.9</b>	<b>2</b>	<b>413.7</b>	<b>1</b>	<b>565.2</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								